

**Г.ДАМЦАГДОРЖ**

*Баянхонгор аймаг
Цагдан хорих байрны
төлөөлөгч, ахлах дэслэгч*

ЦАГДАН ХОРИХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХОРИХ БАЙРНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ

Улсын их хурлаас 2002 онд батлагдсан “Эрх зүйн шинэтгэл”-ийн арга хэмжээний хүрээнд “Баривчлах, цагдан хорих байр”- нь цагдаагийн байгууллагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд шилжин ирж, хорих байрны нөхцөл журам, стандартыг орчин үеийн жишигт хүргэх зорилт тавин МУ-ын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Сэжигтэн яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нийцүүлэн цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж ирсэн.

Манай улсын эрүүгийн хууль тогтоомжийн онцлогоос шалтгаалан хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагчийг цагдан хорьж, мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг төдийгүй эрүүгийн хуулийн тусгай ангийн дийлэнх зүйл анги нь хорих ялын санкцтай, шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ялаар шийтгэгддэг тул энэ нь эрүүгийн нөхцөл байдалд нөлөөлөн ШШГБайгууллагыг улс орны үдэсний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй, онцгойлон анхаарах ёстой субъект болгож байдаг.

Нийгмийн эерэг сөрөг үзэгдэлүүд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, цагдан хорих байрны дотоод нөхцөл байдалд тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлэхээс гадна хүнд ноцтой хор уршиг учруулсан гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч нар ихэнхдээ цагдан хоригддог тул энэ нь тухайн гэмт этгээдийн хувийн зан байдал, гэмт санаа бодол, ял завших болон бусад хууль бус санаархал, субъектив шинжээс хамааран хорих ангийн дотоод болон гадаад нөхцөл байдлыг хүндрүүлэх нэг шалгаан болж байдаг. Энэ байдал нь албан хаагчийн үүрэгт ажилд нь хөндлөнгөөс нөлөөлөн албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, өөрт ашигтай байдлаар хууль бус шийдвэр гаргуулахыг эрмэлзсэн үйлдэл, дарамт шахалт үзүүлэх, амь нас, эрүүл мэндэд нь халдах, ялтан хоригдогч өөртөө болон бусдын бие, амь нас эрүүл мэндэд хохирол учруулах үйлдэл гарсаар байгаа нь ШШГБайгууллага харьяа хорих анги, баривчлах байр, цагдан хорих байранд аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг бодит судалгаанд тулгуурлан цогц байдлаар авч хэргэжүүлэх шаардлага гарч ирснийг харуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төр нийгмийг гэмт халдагаас хамгаалах, гэмт явдалтай тэмцэх эрүүгийн ялын бодлогыг хэрэгжүүлэгч чухал субъект бөгөөд “Эрүүгийн бодлого буюу төрийн зүгээс гэмт явдлын өсөлтийг бууруулах, тогтворжуулах зорилтыг хангаж, оновчтой бодлого боловсруулан хэрэгжүүлэх замаар нийгмийг гэмт халдлагаас хамгаалах идэвхитэй үйл ажиллагаа”⁴⁸-ны салшгүй нэг

⁴⁸ Л.И.Беляева.”Эрүүгийн бодлого ба түүнийг дотоод хэргийн байгууллагаас хэргэжүүлэх нь” 2003.с.7

хэсэг нь эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа юм.

Дэлхийн бусад улс орнуудад төрөл бүрийн ашиг сонирхол бүхий халдлага дайралт ихээр үйлдэгдэж түүний халдлагын зүйл нь хорих байгууллага болох хандлага түгээмэл болсон энэ цаг үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хорих анги, цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах талаарх эрх зүйн зохицуулалт дутмаг, энэ сэдвийн судлагдсан байдал хангалтгүй байгаа нь өнөөдрийг хүртэл хорих байрны аюулгүй байдлын тухай ойлголт орхигдож ирсний илрэл юм.

Урьд өмнө Цагдан хорих байранд үйлдэгдсэн гэмт хэргүүдийн шинж, шалтгаан нөхцлийг судлахад хорих байранд анх хоригдсон болон хорих нөхцөл, гэмт хэргийн үйлдэл, ялын хэмжээ, мөрдөн шалгах ажиллгааны явц байдлаас шалтгаалсан хоригдогсдын сэтгэлзүйн цочрол, онцлогоос хамааран үйлдэгдсэн байх төдийгүй тухайн хэргийг цагдан хорих байрны харуул хамгаалалт, алба хаагчдын үүрэг гүйцэтгэлтийн сул тал, хорих байрны онцлогийг нарийн судалж, тодорхой цаг хугацаа, үйл явдалд тохируулан ноцтой байдлаар үйлдэгдсэн байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал хоригдогсдын зүгээс албан хаагч, бусад сэжигтэн, яллагдагчийн амь нас, эрүүл мэндэд шууд санаатай халдаж бүлэглэн болон ганцаараа оргох, завдах, бусдыг бэлгийн болон санхүүгийн бусад шатгаанаар дарамтлах, гэмт бүлэглэл, зохион байгуулалттай бүлэглэлийн шинжтэйгээр захиалгат болон хувийн ашиг сонирхолын үүдээс гэмт хэрэг үйлдэж автомашин, тусгай тоног төхөөрөмж, дэвшилтэт технологи ихээр ашиглах хандлагатай болсон.

Иймд цагдан хорих байранд аюулгүй байдлыг хангах арга хэмжээг бүх талаас нь тодорхой системтэйгээр зохион байгуулж үр дүнг бодитоор тооцож ажиллаж байгууллагын инженер техникийн байгууламж, хамгаалалтын тоног төхөөрөмжийн чанар хүртээмжийг сайжруулах, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах зэрэг тодорхой ажлууд хийх шаардлатай.

Нэг. Цагдан хорих байранд аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай ойлголт.

МУ-ын “Аюулгүй байдлын тухай хууль”, бусад эрх зүйн актуудад хэдийгээр хорих байрны аюулгүй байдлын талаар тусгайлан заасан зүйл байхгүй боловч “Цагдан хорих байрны аюулгүй байдал”-ын тухай ойлголтыг одоогийн хэмжээнд тодруулахийг зорьлоо.

Зарим судлаачид “Хорих анги, цагдан хорих байрны аюулгүй байдал”-ыг түүний үйл ажиллагааны онцлог, зорилго, зорилттой нь уялдуулан дараах байдлаар тодорхойлсон байна: Энэ сэдвээр судалгааны ажил түлхүү хийж байгаа докторант Ц.Очгэрэл “Хорих ангийн аюулгүй байдал гэдэг нь хорих анги, баривчлах байр, цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, ноцтой хор уршиг, учруулж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зорилгоор эрх, үүрэг бүхий субъектүүдээс хэрэгжүүлж буй тасралтшинж чанартай арга хэмжээний цогц, оновчтой бүтэц бүрдэх явдал”⁴⁹ гэж тодорхойлж болох юм гэжээ.

⁴⁹ “Хууль дээдлэх ёс” сэтгүүл УБ, 2010 он 4 /31/ 49 дэх тал

Цагдан хорих байрандх аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулахын тулд түүний зорилго, агуулгыг нь мэдэж тодорхой зарчимд тулгуурлан, хорих байрны онцлог, бодит нөхцөл байдал тохируулан, тодорхой судалгаанд үндэслэн явуулах ёстой бөгөөд аюулгүй байдлын нөхцөл байдлыг тодрхойлохдоо гадаад болон дотоод хүчин зүйлсийг тогтоож тохирсон арга хэмжээг зохион байгуулж хэргэжүүлэх замаар тухайн зорилтыг хангана.

Цагдан хорих байрны аюулгүй байдлын агуулга, мөн чанар нь албаны өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа, бүтэц, орон тоо, барилга байгууламж, бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлт, ур чадвар, хамгаалалтын хүч хэрэгсэл, нийгмийн болон байгалын хүчин зүйл, тухайн байгууллагын удирдлага зохион байгуулалтын ажил, арга барил, эрсдэлийг урьдчилан тооцоолох, даван туулах чадвар, удирдах дээд шатны байгууллагын бодлого, шийдвэр зэрэг олон зүйлтэй холбон тайлбарлаж болох боловч энэ бүгдийг хамгийн оновчтой арга хэрэгслээр зохион байгуулсан, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, шуурхай таслан зогсоож чадсан байх нь гол үр дүн болдог. Үүнээс үзвэл “Цагдан хорих байранд аюулгүй байдлыг хангах гэдэгт тухайн хорих байрны хэвийн үйл ажиллагаа, хүний эрхийг хуулийн дагуу хангахын тулд удирдлага зохион байгуулалт, урьдчилан сэргийлэх биечилсэн ажил үүрэг, гүйцэтгэх ажлын арга хэмжээг тодорхой судалгаанд үндэслэн цогц байдлаар, оновчтой зохион байгуулах”-ыг ойлгож болох юм.

Хоёр. Цагдан хорих байрны аюулгүй байдалд нөлөөлж буй дотоод, гадаад хүчин зүйл.

Дотоод хүчин зүйл:

1. Албаны удирдлага зохион байгуулалтын ажил, ажиллах арга барил. Энхүү хүчин зүйл нь тухайн хорих ангийн аюулгүй байдлыг хангах ажлыг хэрхэн зохион байгуулах, үр дүнг тооцох, ач холбогдлыг дээшлүүлэх талаар хэрхэн ажиллаж байгаатай тухайн хорих ангийн аюулгүй байдал шууд хамааралтайгаар тайлбарлагддаг

2. Цагдан хорих байрны хоригдогсдын дотоод уур амьсгал буюу гэмт санаа бодол, гэмт хэрэг үйлдэгдэх боломж, сэдэлт, учирч болох хор уршиг түүний хэр хэмжээгээр, тухайн цагдан хорих байрны аюулгүйн нөхцөл байдал тодорхойлогдоно.

3. Алба хаагчдын тоо, ээлжийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлтийн чанар, мэргэжлийн ур чадвар, сонор сэрэмж, албаны бэлэн байдлыг дээшлүүлэх, харуул хамгаалалтыг зохион байгуулах хэлбэр нь аюулгүй байдлыг хангах чухал үзүүлэлт юм.

4. Хамгаалалтын техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, байнгын хэвийн үйл ажиллагааг хангаж, санхүүгийн болоод бусад эд зүйлийн хангалт үйлчилгээ

5. Хорих байрны байршил газар зүйн онцлог, барилга байгууламжийн чанар архитектур зэрэг нь цагдан хорих байрны дотоод аюулгүй байдалд чухал нөлөө үзүүлдэг.

Гадаад хүчин зүйл:

1. Нийгмийн хүчин зүйл буюу нийгмийн амьдралд болж буй сөрөг үзэгдэлүүд жагсаал цуглаан, суулт өлсөглөн, эрх зүйн шинэтгэл, хуулийн өөрчлөлт гэх мэт шалтгаанаар хоригдогсдод буруу ойлголт, итгэл үнэмшил бий болдог.

2. Хоригдогсдын гадна хань харилцаанаас ирэх нөлөөл буюу улс төр, бизнес, эрүүгийн гэмт бүлэглэлийн зүгээс

албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах байдал түгээмэл байдаг бөгөөд энэ нь хоригдогсдын болон алба хаагчдын гэр бүлд заналхийлэл, халдлага байдлаар илэрдэг.

3. Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлсүүд энэ нь тухай хорих ангийн байршил орон нутгийн онцлогоос хамаарахаас гадна хорих байрны хориотой бүсийн стандартыг хэрхэн мөрдөж байгаатай шууд холбоотой байна. Дийлэнх цагдан хорих байрууд тухайн орон нутгийн төв суурин газар бусад барилга байгууламжтай маш ойрхон, зарим нь өөр байгууллагын байранд, түүний хонгилд байрладаг зэрэг нь тухайн цагдан хорих байрны аюулгүй байдлыг улам хүндрүүлэх нэг шалтгаан болдог.

4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй төрөл бүрийн мэдээллээс шалтгаалан цагдан хорих байранд хоригдогсдын сэтгэлзүйд хүчтэй нөлөөлж хорих байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах нөхцөл бүрддэг.

Иймд цагдан хорих шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсронгуй болгон үр дүнтэй зохион байгуулахын тулд:

1. Хорих байрны аюулгүй байдлыг хангах тухай холбогдох хууль эрх зүйн үндсийг тодорхой болгож ШШГТухай хуульд тусган хэрэгжүүлэх
2. Алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэн, аюулгүй байдлын талаарх мэдлэг, нарийвчилсан ойлголт өгөх сургалтыг идэвхитэй зохион байгуулах
3. Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах ажилд орчин үеийн техник технологийн тэвшлийг түлхүү ашиглах шаардлагатай байна.



Н.АНАР
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэл судлал
төвийн эрдэм
шинжилгээний ажилтан,
дэслэгч

НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЧИГ ҮҮРЭГ БУЮУ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монгол Улсын хорих байгууллага түүхэн хөгжлийнхөө явцад гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн улмаас хорих ял эдлэгсэдийг сурган хүмүүжүүлэх талаар тодорхой бодлогыг барьж, эрх зүйн баримт бичгийг гаргаж байсан. Тухайлбал, 1924 оны 8 дугаар сард МАХН-ын 3 дугаар их хурлаас “Гяндангийн дотоод байдлыг сайжруулах, хэрэгтэн ардуудыг гэгээрүүлэх тухай”, 1934 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын анхдугаар их хурлаас ялтан хэрэгтэнийг хорихдоо сурган хүмүүжүүлэх ажлыг чухалчлах хэрэгтэйг онцлон тэмдэглэж байсан бөгөөд 1931 оны “Монгол Улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль”, 1966 оны “Засан хүмүүжүүлэх хөдөлмөр хууль”-уудад хоригдогсодыг хөдөлмөрт сургах, мэргэжил эзэмшүүлэх зэргээр тэднийг нийгэмшүүлэх, сургалт, нөлөллийн ажил зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж иржээ. Түүнчлэн 1997 он хүртэлх хугацаанд Хорих байгууллагуудын Удирдах төв байгууллагын бүтцэд “Улс төр, хүмүүжлийн хэлтэс”-ийн зохион байгуулалттайгаар хорих ангиудад “Сурган хүмүүжүүлэгч” хэмээх ажилтан ажиллаж байсан бол 1997-2003 онд хоригдолтой холбогдсон бүхий л эрх зүйн харилцааг зохицуулж, тэдний эрх ашгийг